



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/101

Арвайхээр

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2.а, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/02 дугаар тогтоолын 2.2.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Орон нутгийн өмчит байгууллагуудын ашиглалтгүй үл хөдлөх хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц. Ганболд (аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: З.Балданям (аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ц.Идэрсайхан (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ц. Хашхүү (аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)

Б.Валя (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын ерөнхий Санхүүч)

Н. Сэдэд (аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын төсөв, санхүү хариуцсан ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Г. Ариунаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан мэргэжилтэн)

2.Ажлын саналыг 2021 оны 03 дугаар сард багтаан Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг (Ц. Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100222